



## ХИЧЭЭЛ 14

УНШИХ ЗҮЙЛ: МАТАЙ 24:27, 30,31,42; I ТЕСАЛОНИК 4: 16,17; ИЛЧЛЭЛТ 1:7; АГУУ МЭТГЭЛЦЭЭН, Х. 640-645.

# Тэр Эргэж Ирнэ

*Хэн нэг хүн ирээд чамайг нэгэн онцгой газар руу дагуулж явахаар болоход чи баярладаг уу? Удахгүй нэгэн онцгой хүн хүрч ирээд чамайг гэр рүүгээ авч явах болно.*

# Д

элхий дээр амьдардаг Бурханы хүүхдүүд олон жилийн өмнө бяцхан Есүс мэндэлж, том хүн болсон гэдгийг мэддэг. Тэр биднийг аврахын тулд амиа өгсөн гэдгийг ч

бас мэднэ. Бурхантай амьдрахаар буцсан гэдгийг тэд мэддэг. Есүсийг энэ дэлхий дээр

дахин хүрч ирнэ гэдгийг ч тэд бас мэднэ.

Дэлхий дээр амьдардаг Бурханы хүүхдүүд энэ бүхэн удахгүй болохыг сайн мэддэг. "Би удахгүй эргэж ирнэ" гэж Есүс хэлсэн. "Газар дэлхий дээр гамшиг их гарах болно. Дайн тулаан их гарна. Газар хөдлөлтүүд болно. Гэвч бүү санаа зов. Та нарыг Мөнхийн улс руугаа аваачихаар би удахгүй эргэж ирэх болно."

Тийм ээ, дэлхий дээр маш олон газар хөдлөлтүүд болсон. Маш олон дайн болсон. Янз бүрийн зовлон бэрхшээлүүд болсон. Гэвч Бурханы хүүхдүүдэд санаа зовох хэрэг байхгүй.

**Цээжлэх Ишлэл:**  
"Харагтун, Тэр үүлсийн хамт ирнэ"  
илчлэлт 1:7.

**Тол Санаа:**  
Есүс удахгүй ирнэ.





Есүс удахгүй ирж, тэднийг гэртээ аваачна гэдгийг тэд өөрсдөө сайн мэдэж байгаа.

"Та нарыг авахаар намайг очиход дэлхий дээрх хүн бүхэн намайг харах болно" гэж Есүс хэлсэн. "Би аянга цахилгаан мэт хүрч ирнэ. Би олон тэнгэр элчээ дагуулсаар үүлэн дундаас гарч ирнэ. Тэд та нарыг цуглуулж Надтай тэнгэрт уулзуулна."

Бурханы хүүхдүүд тэнгэр өөд харуулддаг. Түүнийг яг хэзээ ирэхийг хэн ч мэдэхгүй. Гэвч ирж яваа гэдгийг нь Бурханы хүүхдүүд мэднэ.

Мөнхийн улс дахь бүх тэнгэр элч нар үүнийг мэднэ. Түүнийг дэлхийд дахин очиж, хүүхдүүдээ аваад гэртээ ирнэ гэдгийг тэд сайн мэддэг. Гэхдээ яг хэзээ Есүс эргэж ирэхийг тэдний хэн нь ч мэдэхгүй. Тэр өдөр Бурхан агуу их бүрээ татуулна гэдгийг л тэд сайн мэдэж байгаа. Дэлхийн өнцөг булан бүрт байгаа Бурханы хүүхдүүдийг цуглуулахаар тэд Есүстэй хамт дэлхий рүү очно гэдгээ мэдэж байдаг. Тэнгэр элч нар тэр мөчийг баяртай хүлээж байна. Бурханы хүүхдүүдийг угтан авахдаа дуулах дууг тэд бэлдэж байгаа.

Бурханы хүүхдүүд хүлээсээр л. "Тэр нээрээ ирэх юм болов уу?" гэж зарим нь асуудаг. "Мэдээж, Тэр ирж яваа" хэмээн нөхөд нь урамшуулна. Есүс амлалтаасаа хэзээ ч зөрчдөггүй. Иймд тэнгэр өөд харуулдаад л бай.

Гэнэт л тэр онцгой өдөр ирэх болно. "Би цаашид хүлээж чадахгүй нь. Цаашид хүлээж чадахгүй нь" хэмээн Есүсийн хэлэх дуу Мөнхийн улсаар дүүрэн цуурайтах болно. "Алив, явж хүүхдүүдийг минь цуглуулцгаая."

Тэнгэр элч нар ч баярлан хөөрнө. Тэгээд алгаа ташина. Тэд баярласандаа дуулж, бүжиглэцгээнэ. Энэ бол хамгийн их дуу шуугиантай өдөр байх болно.

Есүс болон түүний элч нар дэлхий дээгүүр хурдан ниснэ. Тэд аянга цахилгаанаас ч хурдан, нарнаас ч илүү гэрэлтэй. Тэдний эргэн тойронд гэрэлтэх үүлс Есүсийг бүрхсээр дэлхий рүү орж ирэх болно. "Тэр ирж байна" хэмээн Бурханы хүүхдүүд хашгиралдана. "Есүс ирлээ. Тэр яг хэлснийхээ дагуу хүрч ирлээ."

Бурханы хүүхдүүдийг даруйхан цуглуулж Есүстэй уулзуулахаар тэнгэр элч нар яарах болно. Энэ бол бидний хамгийн аз жаргалтай өдөр юм. Есүс биднийг Мөнхийн улс руугаа авч явах тэр өдөр бол хамгийн агуу өдөр байх болно.



# Дасгал Ажил

## ШАББАТ

Энэ долоо хоногийн туршид өдөр бүр Библийн түүхээ уншиж, цээжилсэн ишлэлийг нь хамтдаа давтаарай.

**Хараггун,** .....Саравчлах.

**Тэр үүлсийн**.....Дээшээ заах.

**хамт ирнэ.** .....Гараа урагш сунгаж  
байгаад цээж рүүгээ  
татах.

**Илчлэлт 1:7** .....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

## НЯМ

Шаббат хичээл дээр хийсэн Дахин ирэлтийн зургаа хэн нэгэнтэй хуваалцаж, түүнд Есүс удахгүй ирэх тухай болон яагаад ирж байгааг тайлбарлахад нь хүүхдээ урамшуулаарай. (Эсвэл том үүлэн дунд хаан ширээндээ залрах Есүсийн зургийг зураарай. Тэнгэр элч нар түүнийг хүрээлсэн байна. Үүлний хэсэг дээр нь хөвөн наагаарай.)

## ДАВАА

Матай 24:27, 30, 31, 42; 1 Тесалоник 4:16, 17, Илчлэлт 1:7-г хамтдаа уншаарай. Асуух: Есүсийг үүлэн дундаас гарч ирэхэд чи ямар дуу чимээ сонсох вэ? Чи юу хийх вэ?

Хүүхдэдээ гэнэтийн бэлэг бэлдээрэй. Есүсийн дахин ирэлт хүмүүст гэнэтийн бэлэг байх болно гэдгийг тайлбарлан хэлнэ үү. Яг хэзээ гэдгийг нь бид мэдэхгүй ч Түүнийг ирж байгааг бид мэднэ.

## МЯТМАР

Хүүхдэдээ бүрээний зураг харуулаад, зарим бүрээгээр тоглосон хөгжим сонсоорой. Асуух: Есүсийг

ирэхэд хэн бүрээ үлээх вэ? "Бид зэрэгцэн зогсоод" дууг залбирлын өмнө хамтдаа дуулаарай. Түүнийг хурдан ирээч гэж залбираарай.

## ЛХАГВА

Хүүхдээ аялалд явах гэж байгаа юм шиг юм хум бэлдүүлээрэй. (хаашаа гэдгийг нь хэлэх хэрэггүй)

Асуух: Бид мөнхийн улс руу явахын тулд ямар нэгэн юм бэлдэх хэрэгтэй юу? (үгүй) Харин бид энэ агуу аялалд өөрсдийгөө бэлдэх ёстой юу? (Тийм) Яаж? (зүрх сэтгэлээ Есүст өгөх)



## ПҮРЭВ

Есүсийг ирэх үед хүмүүсийн харах аянга цахилгааныг төсөөлөн ярилцаарай. Хүүхдээрээ зүүн зүгийг заалгаарай. Есүсийг ирэхэд зүүн зүгт харагдах үүлсийн тухай яриарай. "Бурхан бол сайн" дууг дуулаарай. Түүнийг эргэж ирэхэд нь бэлэн байхад маань туслаач гэж залбираарай.

## БААСАН

Гэрийнхэнтэйгээ хамт Библийн түүхийг жүжиглээрэй. Гэрлээ унтраагаад Есүсийг эргэж ирэх үед гарах цахилгааныг төсөөлүүлээрэй. Есүсийн дүрд тоглож байгаа хүний нүүр лүү гар чийдэн тусга. Тогооны тагаар аянга дуурайлган нижиглүүлээрэй.

"Бид зэрэгцэн зогсоод" дууг хамтдаа дуулаад дараа нь удахгүй ирнэ гэж амласанд нь Түүнд талархаарай.